

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 32-Р ХОРООНЫ НУТАГТ ОРШИХ
ХИЙТ ХӨНГӨН БЕТОН ГУЛДМАЙН ҮЙЛДВЭРИЙН 2023 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 32-Р ХОРООНЫ НУТАГТ ОРШИХ
ХИЙТ ХӨНГӨН БЕТОН ГУЛДМАЙН ҮЙЛДВЭРИЙН 2023 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5717906

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН

/Ж.БАТЗОЛБОО/

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“ЖИ ЭС ДОРНЫН ХӨГЖИЛ” ХХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



/А.АМАР-ОТГОН/

“ЖИ ЭС ДОРНЫН ХӨГЖИЛ” ХХК-НИЙ
МЕНЕЖЕР

/Д.УЯНГА/

УЛААНБААТАР ХОТ

2023 ОН

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
1.1. Төслийн нэр	5
1.2. Төслийн зорилго	5
1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр хаяг	5
1.4. Төслийн байршил	5
1.5. Төслийн хүчин чадал	6
1.6. Үйлдвэрийн түүхий эд, материал	7
1.7. Эцсийн бүтээгдэхүүн	9
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	16
ДӨРӨВ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..	21
ТАВ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	26
ЗУРГАА. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	29
6.1. Агаарын чанарын мониторинг	29
6.2. Усны чанарын мониторинг	30
6.3. Хөрсний чанарын мониторинг	31
ДОЛОО. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	33
ХАВСРАЛТ	34

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Үйлдвэрийн байршил	6
Зураг 2. Хийт хөнгөн бетон гулдмайн үйлдвэр	6
Зураг 3. Цементийн силос буюу силосд цемент шахаж буй байдал	7
Зураг 4. Унд-ахуйн зориулалтаар ашиглаж буй гүний худаг	8
Зураг 5. Унд ахуйн гүний худгийг тоолууржуулсан байдал	8
Зураг 6. Үйлвэрийн талбай дахь задгай түүхий эд хадгалах хэсэгт саравч байгуулсан нь	12
Зураг 7. Үнс хадгалах талбайн хучлагыг түр үнс ачиж буй байдал	12
Зураг 8. Тоосжилттой үед үйлдвэрийн орчныг усалж чийгшүүлсэн байдал	13
Зураг 9. Үйлдвэрийн зарим жижиг техник хэрэгсэлд засвар үйлчилгээ хийж буй байдал	13
Зураг 10. Үйлдвэрийн зарим машин механизмд засвар үйлчилгээ хийж буй байдал	14
Зураг 11. Уурын зуухны үнсийг цэвэрлэх, ээлжит засвар үйлчилгээ хийж буй байдал	14
Зураг 12. Үйлдвэрийн хашаанд үхрийн нүдний суулгац тарьж буй ажлын явцаас ..	17

Зураг 13. Ажилчид зүлэгжүүлсэн талбайд нөхөн тарилт, арчилгаа усалгаа хийж буй байдал	17
Зураг 14. Үйлдвэрийн барилгын баруун талд тарьж ургуулсан ногоон байгууламжийн ургалтын байдал	17
Зураг 15. Түүхий эд материалын талбайн орчимд тарьсан ногоон байгууламжийн ургалтын байдал	18
Зураг 16. Оффисын барилгын орчны зүлэгжүүлэлтийн ургалтын байдал	19
Зураг 17. Ажилчдын амрах байрны орчмын талбайд тохижилт, зүлэгжүүлэлт хийсэн байдал	19
Зураг 18. Хүлэмжинд ажилчдын хүнсний хэрэгцээнд ашиглах нарийн ногоо тарьсан байдал	20
Зураг 19. Ажилчид ХАБЭА-н сургалтанд хамрагдаж буй байдал	22
Зураг 20. Үйлдвэрийн ХАБЭА-н шаардлага хангасан хувцас, хэрэгслийн иж бүрдэл	23
Зураг 21. Үйлдвэрийн орчинд ажиллаж буй ажилчид аюулгүй ажиллагааны шаардлага хангасан хувцас хэрэгслээр хангагдсан байдал	23
Зураг 22. Үйлдвэрт бэлэн байлгадаг анхан шатны тусламжийн хэрэгслүүд	24
Зураг 23. Шаардлагатай үед зарим ажилчдад анхан шатны тусламж үзүүлж буй байдал	24
Зураг 24. Гал унтраах зөөврийн болон суурин тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг бэлтгэсэн байдал	25
Зураг 25. Үйлдвэрийн хашааны гадны орчныг нийт ажилчдын бүрэлдэхүүнээрээ цэвэрлэж буй байдал	27
Зураг 26. Үйлдвэрийн хашаа руу орох хэсгийн харагдах байдал	27
Зураг 27. Ахуйн хатуу хаягдлыг ангилан ялгаж хуримтлуулах цэг	28
Зураг 28. Бохирын цооногийн гаднаас харагдах байдал	28
Зураг 29. Уурын зуухны яндангаас ялгарах бохирдуулагчийн хэмжилт хийж буй байдал	29
Зураг 30. Үйлдвэрийн гадна орчны агаарын чанарын хэмжилт хийж буй байдал ..	30
Зураг 31. Хөрсний дээж авч буй байдал	31

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Газар эзэмших зөвшөөрөл бүхий талбайн эргэлтийн цэгүүдийн солбицол	5
Хүснэгт 2. Гүний худгуудын мэдээлэл	8
Хүснэгт 3. Үйлдвэрийн талбайн орчны агаарын чанарын хэмжилтийн үр дүн	29
Хүснэгт 4. Уурын зуухны яндангаас ялгарах бохирдуулагч бодисуудын	29
Хүснэгт 5. Усны химийн шинжилгээний үр дүн	30
Хүснэгт 6. Хөрсний агро-хими шинж чанар	31
Хүснэгт 7. Хөрсний механик бүрэлдэхүүн	32
Хүснэгт 8. Хөрсний хүнд металлын агууламж	32

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

Хийт хөнгөн бетон гулдмайн үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

1.2. Төслийн зорилго

Энэхүү үйлдвэр нь барилгын үндсэн материал болох хийт хөнгөн бетон гулдмайг олон улсын стандартад нийцүүлэн чанарын өндөр түвшинд үйлдвэрлэж дотоодын зах зээлд нийлүүлэх, улсын төсөвт төлөх татварын орлогыг нэмэгдүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр хаяг

“Жи эс дорнын хөгжил” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9019060091

Регистрийн дугаар: 5717906

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, бага тойруу, сүхбаатар 13/1, 1202 тоот


Утас: 99110837, 99083443

1.4. Төслийн байршил

“Жи эс дорнын хөгжил” ХХК-ийн Хийт хөнгөн бетон гулдмайн үйлдвэр нь Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт, Улаанбаатар хотоос Баруун аймгууд руу чиглэсэн авто замын урд талд 650 м орчим зайтай, Сонгинохайрхан уулын бэлд байрладаг. Үйлдвэрийн талбай руу хатуу хучилттай авто замаас салаад 1 км орчим шороон замаар явж хүрдэг.

Хүснэгт 1. Газар эзэмших зөвшөөрөл бүхий талбайн эргэлтийн цэгүүдийн солбицол

Цэгийн дугаар	Өргөрөг	Уртраг	Цэгийн дугаар	Өргөрөг	Уртраг
1	47°52'56.63"N	106°38'49.17"E	1	47°52'55.32"N	106°38'50.12"E
2	47°52'58.74"N	106°38'47.49"E	2	47°52'56.63"N	106°38'49.17"E
3	47°52'58.38"N	106°38'46.08"E	3	47°52'57.43"N	106°38'52.60"E
4	47°52'59.55"N	106°38'45.39"E	4	47°52'58.84"N	106°38'58.67"E
5	47°52'59.69"N	106°38'45.31"E	5	47°52'59.19"N	106°39'0.17"E
6	47°53'2.62"N	106°38'57.93"E	6	47°52'57.95"N	106°39'0.78"E
7	47°52'59.24"N	106°39'0.40"E			



Зураг 1. Үйлдвэрийн байршил

1.5. Төслийн хүчин чадал

Хийт хөнгөн бетон гулдмайн үйлдвэр нь 2014 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар нийт 35 хүнийг ажлын байраар ханган ажиллуулж байна. Энэхүү үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжүүд нь өндөр зэрэглэлийн бетон гулдмай үйлдвэрлэхэд нэн тохиромжтой, хүчин чадал сайтай, бүрэн автомат удирдлагын системтэй.

Үйлдвэр нь жил бүрийн 4-р сараас 10-р сар хүртэл улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жилд дунджаар 136 хоног ажилладаг. Хоногт дунджаар 120 м³, жилд дунджаар 16320 м³ бетон гулдмай үйлдвэрлэх хүчин чадалтай.



Зураг 2. Хийт хөнгөн бетон гулдмайн үйлдвэр

1.6. Үйлдвэрийн түүхий эд, материал

Үйлдвэрийн үндсэн түүхий эдүүд нь элс, цемент, шохой, нэмэлт бодис, үнс гэсэн материалууд байдаг. Эдгээр түүхий эд материалуудыг дотоодын зах зээлээс харилцагч байгууллагуудтай байгуулсан түүхий эд нийлүүлэх гэрээний дагуу худалдан авч ашигладаг.

Цемент: Үйлдвэрт жилд дунджаар 5018.136 тн цемент ашигладаг бөгөөд цементийн хэрэглээг “Техник импорт” ХХК-аас авч ашигладаг. Цементийг салхинд хийсэхгүй, ус чийгэнд автахгүй, орчныг бохирдуулахааргүй байх зориулалтын нөөцийн сав буюу силосд хадгалдаг.



Зураг 3. Цементийн силос буюу силосд цемент шахаж буй байдал

Шохой: Хийт хөнгөн бетон гулдмайн найрлагад шохойн чулуу чухал үүрэгтэй бөгөөд идэвхитэй кальцийн исэл ба магнийн ислийн хольц ($\text{CaO}+\text{MgO}$) 70-аас дээш хувь, хэт шаталт 2-оос илүүгүй хувь агуулсан, унтрах хурд 5.25 минут, хурдан ба дунд унтралттай кальцийн шохойг ашиглаж байна. Шохойг “Хөтөл цемент шохой” ХК-иас нийлүүлдэг бөгөөд “MNS 347:2002” стандартын шаардлага хангасан шохойг жилд дунджаар 7561.106 тн-ыг ашигладаг.

Элс: Үйлдвэрт хэрэглэх элсийг “Эм Ти Ти бабел инженеринг” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу тээвэрлэн авчирч үйлдвэрийн хашаанд буюу барилгын баруун талд байрлах түүхий эдийн ил талбайд буулган ашигладаг. Жилд дунджаар 6787.19 м³ элс ашигладаг.

Үнс: Хийт хөнгөн бетон гулдмайн үйлдвэрлэлд шаардлагатай үнсийг дулааны 4-р цахилгаан станцын үнсэн сангаас авч ашиглаж байна. Жилд дунджаар 19811.515 тн үнсийг үйлдвэрийн технологид ашигладаг.

Нэмэлт бодис: Хийт хөнгөн бетон гулдмайн үйлдвэрийн технологид блокийг барьцалдуулж, хөөлгөх зорилгоор нэмэлт бодис буюу хөнгөнцагааны нунтаг (Aluminum (Al) powder) ашигладаг. Энэхүү нэмэлт бодисыг химийн хортой болон аюултай бодис импортлох тусгай зөвшөөрөл бүхий “Сэлэнгэ-Оюу” ХХК-аас худалдан авч үйлдвэрт ашигладаг бөгөөд 1.103кг/л нягттай шингэрүүлж найруулсан нэмэлт бодисыг цементийн жингийн 1-3%-иар зуурмагт нэмж үйлдвэрлэлд хэрэглэдэг. Жилд дунджаар 35000 кг нэмэлт бодис ашигладаг.

Ус хангамж: Үйлдвэрийн технологийн болон унд ахуйн зориулалтаар ус хэрэглэдэг ба үйлдвэрийн талбайд 2 ширхэг гүний худаг гарган ашиглаж байна.

Унд ахуйн зориулалтаар ашиглаж буй гүний худаг нь 100 метрийн гүнээс татсан 2.0 л/сек ундаргатай. Харин үйлдвэрийн технологийн хэрэгцээний усыг 85.5 м-ийн гүнтэй, 4.8 л/сек ундаргатай гүний худгаас хангадаг.

Хүснэгт 2. Гүний худгуудын мэдээлэл

№	Солбицол		Ундарга	Цооногийн гүн	Зориулалт
	Х (өргөрөг)	У (уртраг)			
1	47°52'58.86"N	106°38'45.95"E	2.0 л/сек	100.2 м	Унд-ахуй
2	47°53'0.79"N	106°38'50.14"E	4.8 л/сек	85.5 м	Үйлдвэрийн технологи

Унд ахуйн зориулалтаар ашиглаж буй гүний худаг нь ажилчдын амрах байр, цайны газрын барилгатай залгаа орших ба гүний худгийг барилгажуулж, ус хэрэглээг тоолуурын заалтаар тооцож байна.



Зураг 4. Унд-ахуйн зориулалтаар ашиглаж буй гүний худаг



Зураг 5. Унд ахуйн гүний худгийг тоолууржуулсан байдал

Үйлдвэрийн технологийн үйл ажиллагааны үед өндөр даралтат уур үйлдвэрлэж блокны зуурмагийг хөөлгөх, хатаах зорилгоор ус ашиглах ба энэхүү ус хэрэглээг уурын зуухны хажууд байрлах гүний худгаас хангаж байна. Тус гүний худгийг мөн тоолууржуулсан бөгөөд 50.0 тн, 20 тн-ын багтаамжтай 2 ширхэг нөөцлүүрт усаа хуримтлуулан үйлдвэрлэлд ашигладаг.

Үйлдвэрт жилд дунджаар 7000 м³, ажилчдын унд ахуйн хэрэглээнд жилд дунджаар 272 м³ ус хэрэглэдэг.

Цахилгаан хангамж: Үйлдвэрийн талбайгаас 1.5 км зайд байрлах 4-р ДЦС-ын дэд өртөөнөөс салбарлуулан цахилгаан эрчим хүчээр хангаж байгаанаас гадна өөрийн хэрэгцээнд зориулж КТПН барьж, 200 м кабель татсан.

Үйлдвэрийн цахилгааны гол хэрэглэгч нь конвейр, холигч, компрессор, насос гэх мэт тоног төхөөрөмжүүд болон оффис, ажилчдын байр, гал тогоо юм. Мөн үйлдвэр доторх болон хашаан доторх гэрэлтүүлэг, цехийн байр, ажиллаж байгаа машин техникийн ойр орчим, ажилчдын байнга явах зам талбайд гэрэлтүүлэг хийсэн бөгөөд эдгээр цахилгаан эрчим хүчний хэрэглээг өөрийн дэд станцаар дамжуулан найдвартай хангаж байна.

Уур, дулаан, нүүрсний хэрэглээ: Хийт хөнгөн бетон гулдмайн үйлдвэрт БНХАУ-д сүүлийн үеийн технологиор үйлдвэрлэгдсэн нүүрс бага хэрэглэдэг, өндөр хүчин чадалтай уурын зуух ашиглаж байна. Тус уурын зуух нь хоногт 10.0 тн нүүрс түлж, 3.2 тн уур үйлдвэрлэдэг. Уурын зуухны яндан нь усан шүүлтүүртэй. Үйлдвэрлэсэн уур, дулааныг шугам хоолойнуудаар дамжуулан автоклав болон цехүүдэд хувиарлан шингэн зуурмагийг хөөлгөх, зүсч биежсэн блокийг хатаах зэрэг үндсэн ажиллагаануудад хэрэглэдэг.

“Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” Монгол Улсын Засгийн газрын 62-р тогтоол болон Нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Нам даралтын халаалтын зууханд түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” А/1377 тоот захирамжийг үндэслэн MNS 6457:200014 стандартын шаардлага хангасан “Мидлинг” баяжуулсан нүүрсийг үйлдвэрт ашиглаж байна.

1.7. Эцсийн бүтээгдэхүүн

Үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүний чанарыг өөрийн лабораторит туршилт хийж шалган “Сийрмэг бетон. Бүтээц ба эдлэхүүн. Техникийн шаардлага MNS-0831:2001” стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нийлүүлэх ба жилд дунджаар 14.5 мян.м³ бетон үйлдвэрлэн зах зээлд нийлүүлдэг.

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт
1	Түүхий эд талбайгаас тоосжилт үүсэх	Элс, үнс хуримтлуулж буй түүхий эдийн талбайг даавуу эсвэл нийлэг материал бүхий хучлагаар хучих	Түүхий эдийн талбайн салхины зонхилох чиглэлийн дагуу төмөр салхины хаалт хийсэн. Түүнчлэн үнсний овоолгыг тоосжилт үүсэхээс сэргийлэн нийлэг болон даавуун материалаар хучилт хийх, шаардлагатай тохиолдолд үйлдвэрийн орчны тоосжилттой хэсгийг усалж чийглэх байдлаар орчны тоосжилтыг бууруулах арга хэмжээ авч ажиллаж байна (Зураг 6-8).
2	Бензин, дизель түлшээр ажилладаг тээврийн хэрэгслүүдийн дутуу шаталтат хөдөлгүүрээс хийн төлөвт бохирдуулагч ялгарч агаарын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй.	Нийт машин механизмуудыг техникийн үзлэг оношилгоонд хамруулах	Үйлдвэрийн эзэмшилд байх суудлын болон бусад тээврийн хэрэгслүүдийг “АТҮТ” ТӨҮГ-ын техникийн үзлэг оношилгоонд хамруулсан болно (Хавсралт 1).
3		Машин техникийн үзлэг оношилгооны үр дүнгээс хамааран стандартын ЗДХ-ээс хэтэрсэн хорт утаа ялгаруулж буй машин техникийн хөдөлгүүрийг шинэчилж сайжруулах арга хэмжээ авах	Техникийн үзлэг оношилгооны үр дүнд үйлдвэрийн эзэмшлийн машин техникүүд нь стандартын ЗДХ-ээс хэтэрсэн хорт хий ялгаруулахгүй байгаа нь тогтоогдсон тул хөдөлгүүрийг шинэчлэх техникийн засвар үйлчилгээ хийгдээгүй болно. Харин шаардлагатай сэлбэг хэрэгслүүд, тос масло солих зэрэг үйлчилгээг тогтмол хийлгэдэг (Хавсралт 2).
4	Уурын зуухны яндангаас ялгарах утаа, тоосны агууламж стандартын ЗДХ-ээс хэтэрч болзошгүй.	Уурын зуухны яндангийн усан шүүлтүүрийн засвар үйлчилгээг тогтмол хийж техникийн үр ашгийг бууруулахгүй байх	Үйлдвэр нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг тул хавар үйлдвэрлэл эхлэхээс өмнө үндсэн техник тоног төхөөрөмж, дамжлагуудад техникийн болон аюулгүй ажиллагааны үзлэг хяналт хийж, шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээ хийж байна (Зураг 9-10).
5		Уурын зуухны үнс баригч төхөөрөмжийн ёроолд тунасан үнсийг өдөр бүр зайлуулж цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийх	Уурын зуухны үнс баригч төхөөрөмжийн ёроолд тунасан үнсийг өдөр бүр цэвэрлэн авч тусгай үнсний талбайд түр хадгалах ба үйлдвэрлэлд түүхий эд болгон дахин ашигладаг (Зураг 11, Хавсралт 3).
6	Хууль эрх зүйн орчны зөрчил бий болох	Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар “Ус ашиглуулах дүгнэлт” гаргуулах, зөвшөөрөл авч, гэрээ	✓ Ус ашиглуулах дүгнэлт: 2023.08.16-ны өдрийн 04/451 дугаартай албан бичиг, Ус ашиглуулах дүгнэлтийн дугаар: УАД 23/67

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт
		байгуулан ажиллах	✓ <i>Хаягдал усны дүгнэлт</i>: 2023.08.16-ны өдрийн Дугаар ХҮ 23/111 тоот дүгнэлт ✓ <i>Ус ашиглах эрхийн бичиг</i>: Дугаар – 2018/11, Хүчинтэй хугацаа 2024.09.13, 3 жилийн хугацаатай сунгагдсан. ✓ <i>Ус ашиглах гэрээ</i>: 2023 оны 09 сарын 11-ний өдөр НБОГ-тай байгуулсан. Дугаар: 2023/28, Гэрээний хугацаа: 1жил (Хавсралт 4, 5, 6, 7)
7	Хууль эрх зүйн орчны зөрчил бий болох	Ус ашигласны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх	Ус ашиглуулах дүгнэлт болон ус ашиглах гэрээнд заасны дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны болон хаягдал усны төлбөрүүдийг улсын төсөвт жил бүр төлж байна. 2022 онд ус ашигласны төлбөрт нийт 3'020'800.0 төгрөг төлсөн. 2023 оны төлбөрийг мөн энэ онд багтаан төлнө (Хавсралт 8) .
8	“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10 ¹ -р зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитыг 2 жил тутамд нэг удаа хийлгэх		Байгаль орчны аудитыг 2023 оны 6 дугаар сард мэргэжлийн байгууллага болох “Өртөөлөн” ХХК-аар хийлгэсэн болно. Байгаль орчны аудит гүйцэтгэх гэрээний хуулбар болон аудитын тайлангийн баталгаажсан нүүрний хуулбарыг хавсаргав (Хавсралт 9) .
9	Үйлдвэрийн бүх ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах		СХДЭМТ-тэй 2023 оны 05 сарын 18-ны өдөр байгуулсан “Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ хийх гэрээ”-ний дагуу үйлдвэрийн нийт ажилчид болох 9 хүнийг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулсан. Гэрээний дугаар: 23/ус/52, гэрээний хугацаа: 2023.12.31 хүртэл (Хавсралт 10) .

1. Үйлдвэрийн үндсэн болон туслах түүхий эд материалууд болох элс, үнс, нүүрсийг үйлдвэрийн талбайд ил байдлаар овоолго үүсгэн хадгалдаг. Эдгээр нь хуурайшилт ихтэй, салхитай үед тоосжилт үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг. Иймд түүхий эд хадгалж буй талбайн салхины зонхилох чиглэлийн дагуу төмөр салхины хаалт хийсэн. Ингэснээр түүхий эд, материалын овоолгоос үүсэх тоосжилтыг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлж байна. Түүнчлэн үнсний овоолгыг тоосжилт үүсэхээс сэргийлэн нийлэг болон даавуун материалаар хучилт хийх, шаардлагатай тохиолдолд үйлдвэрийн орчны тоосжилттой хэсгийг усалж чийглэх байдлаар орчны тоосжилтыг бууруулах, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ авч байна.



Зураг 6. Үйлвэрийн талбай дахь задгай түүхий эд хадгалах хэсэгт саравч байгуулсан нь



Зураг 7. Үнс хадгалах талбайн хучлагыг түр үнс ачиж буй байдал



Зураг 8. Тоосжилттой үед үйлдвэрийн орчныг усалж чийгшүүлсэн байдал

2. Үйлдвэрийн эзэмшилд байх суудлын болон бусад тээврийн хэрэгслүүдийг “АТҮТ” ТӨҮГ-ын техникийн үзлэг оношилгоонд хамруулсан. Ингэснээр аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй байгаа болон стандартын ЗДХ-ээс хэтэрсэн агаар бохирдуулагч хий ялгаруулж буй техникүүдийг урьдчилан оношилж аюулгүй байдлыг хангах, агаар орчныг бохирдуулахаас сэргийлэх боломжтой. Үйлдвэрийн тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэгт хамруулсан баримтыг Хавсралт (1)-аас үзнэ үү.
3. Техникийн үзлэг оношилгооны үр дүнд үйлдвэрийн эзэмшлийн машин техникүүд нь стандартын ЗДХ-ээс хэтэрсэн хорт хий ялгаруулахгүй байгаа нь тогтоогдсон тул хөдөлгүүрийг шинэчлэх техникийн засвар үйлчилгээ хийгдээгүй болно. Харин шаардлагатай сэлбэг хэрэгслүүд, тос масло солих зэрэг үйлчилгээг тогтмол хийлгэдэг (Хавсралт 2).
4. Үйлдвэр нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг тул хавар үйлдвэрлэл эхлэхээс өмнө үндсэн техник тоног төхөөрөмж, дамжлагуудад техникийн болон аюулгүй ажиллагааны үзлэг хяналт хийж, шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээ хийж байна. Үйлдвэрийн орчинд хийх боломжтой жижиг засваруудыг үйлдвэрийг талбайд хийдэг бол машин механизм, техник хэрэгслийн томоохон засвар үйлчилгээг авто тээврийн засварын газарт хийлгэдэг (Зураг 9).



Зураг 9. Үйлдвэрийн зарим жижиг техник хэрэгсэлд засвар үйлчилгээ хийж буй байдал



Зураг 10. Үйлдвэрийн зарим машин механизмд засвар үйлчилгээ хийж буй байдал

5. Уурын зуухны үнс баригч төхөөрөмжийн ёроолд тунасан үнсийг өдөр бүр цэвэрлэн авч тусгай үнсний талбайд түр хадгалах ба үйлдвэрлэлд түүхий эд болгон дахин ашигладаг (Зураг 11). Засвар үйлчилгээг тогтмол хийж, үнсийг цэвэрлэснээр уурын зуухны яндангаас ялгарах утаа, тоосны агууламжийг бууруулах боломжтой байдаг. Түүнчлэн Барилга хот байгуулалтын яамнаас уурын зуух, бусад дамжлагууд, тэдгээрийн ашиглалтын төлөв байдал, сорилтын тайлан, акт, хянах хэмжих хэрэгслийг баталгаажуулсан акт зэргийг үндэслэн уурын зуухыг ямар даралтаар ашиглахыг тогтоож, магадлал хийн зөвшөөрөл олгодог. Энэ магадлалыг хийлгэж баталгаажуулсан бөгөөд тайланд хавсаргав (Хавсралт 3).



Зураг 11. Уурын зуухны үнсийг цэвэрлэх, ээлжит засвар үйлчилгээ хийж буй байдал

6. Ус ашиглуулах болон хаягдал усны дүгнэлтийг Туул голын сав газрын захиргаагаар 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдөр гаргуулсан. Ус ашиглуулах дүгнэлтээр унд ахуйд 504 м³/жил, үйлдвэрийн технологид 33000 м³/жил ус хэрэглэх тооцоо гарсан. Хаягдал усны хэмжээ 381.0 м³ бөгөөд ус бохирдуулсны төлбөрт 2023 онд 28560 төгрөг төлөх тухай дүгнэлтэнд тусгасан байна. Ус ашиглах гэрээг 2023 оны 09 сарын 11-ний өдөр НБОГ-тай байгуулсан. Ус ашиглах гэрээнд 2023 оны усны нөөц ашигласны төлбөрийг “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 302 дугаар тогтоолын 1-р хавсралт, “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай”, “Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай”, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолуудын дагуу тоолуурын заалтаар тооцож, 1м³ усны төлбөрт 188.8 төгрөг төлөх тухай тусгасан байна. Гэрээний дугаар: 2023/28, гэрээний хугацаа: 1жил. Ус ашиглуулах дүгнэлт, хаягдал усны дүгнэлт, эрхийн бичиг, гэрээг Хавсралт (4, 5, 6, 7) – аас үзнэ үү.
7. Ус ашиглуулах дүгнэлт болон ус ашиглах гэрээнд заасны дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны болон хаягдал усны төлбөрүүдийг улсын төсөвт жил бүр төлж байна. 2022 онд ус ашигласны төлбөрт нийт 3’020’800.0 төгрөг төлсөн. 2023 оны төлбөрийг мөн энэ онд багтаан төлнө. Төлбөр төлсөн баримт болон төлбар тооцооны хуудсыг Хавсралт (8)-аас үзнэ үү.
8. Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллага болох “Өртөөлөн” ХХК-аар 2023 оны 06 сард хийлгэсэн болно. Байгаль орчны аудитын журам аргачлалд зааснаар аудитын тайлан, түүний дүгнэлт зөвлөмж нь байгууллагын нууцад хамаарах тул зөвхөн Байгаль орчны аудит гүйцэтгэх гэрээний хуулбар болон аудитын тайлангийн баталгаажсан нүүрний хуулбарыг тайланд хавсаргав (Хавсралт 9).
9. СХДЭМТ-тэй 2023 оны 05 сарын 18-ны өдөр байгуулсан “Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ хийх гэрээ”-ний дагуу үйлдвэрийн нийт ажилчид болох 9 хүнийг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулсан. Гэрээний дугаар: 23/ус/52, гэрээний хугацаа: 2023.12.31 хүртэл. Үйлдвэрийн ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах гэрээг Хавсралт (10)-аас харна уу.

ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

1. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны хүрээнд үйлдвэрийн хашаанд нийт 80 ширхэг үхрийн нүдний суулгац тарьж ногоон байгууламж байгуулсан. Түүнчлэн 2022 онд тарьж ургуулсан 0.3 га талбай бүхий зүлэг, ногоон байгууламжийн арчилгаа, усалгааг тогтмол хийж, хөрсийг сийрүүлэх, хог ургамлыг цэвэрлэн ургалтыг сайжруулах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлсэн (Зураг 12-16). Орчны тохижилтын үйл ажиллагаанд үйлдвэрийн нийт ажилчдыг хамруулан ажилласан болно.





Зураг 12. Үйлдвэрийн хашаанд үхрийн нүдний суулгац тарьж буй ажлын явцаас



Зураг 13. Ажилчид зүлэгжүүлсэн талбайд нөхөн тарилт, арчилгаа усалгаа хийж буй байдал



Зураг 14. Үйлдвэрийн барилгын баруун талд тарьж ургуулсан ногоон байгууламжийн ургалтын байдал



Зураг 15. Түүхий эд материалын талбайн орчимд тарьсан ногоон байгууламжийн ургалтын байдал



Зураг 16. Оффисын барилгын орчны зүлэгжүүлэлтийн ургалтын байдал

2. Мөн ажилчдын амрах байрны орчмын талбайг шинээр зүлэгжүүлж, явган хүний зам талбайг засаж тохижуулан ажилчид чөлөөт цагаараа агаарт сууж амрах тав тухтай нөхцөлийг бүрдүүлсэн.



Зураг 17. Ажилчдын амрах байрны орчмын талбайд тохижилт, зүлэгжүүлэлт хийсэн байдал

3. Ажилчдын хүнсний хэрэгцээнд зориулан зарим төрлийн нарийн ногоог ажилчдын амрах байрны урд хэсэгт байрлах хүлэмжинд тарьж ургуулдаг.



Зураг 18. Хүлэмжинд ажилчдын хүнсний хэрэгцээнд ашиглах нарийн ногоо тарьсан байдал

ДӨРӨВ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжилт
1	Ажилчдын болзошгүй осол аваараас сэргийлэх мэдлэг чадвар дутмаг байдлаас шалтгаалж осол аваар гарах, ослын нөхцөл хүндрэх	Ажлын байран дахь ХАБЭА болон болзошгүй осол аваарын үед анхан шатны тусламж үзүүлэх сургалтыг нийт ажилчдын дунд зохион байгуулах	ХАБЭА болон болзошгүй осол аваарын үед анхан шатны тусламж үзүүлэх сургалтыг “Монголын хүний нөөц удирдлагын шинэчлэлийн академи”-тай 2022 оны 05 сарын 17-ны өдөр байгуулсан гэрээний дагуу тогтсон хуваариар ажлын байранд явуулдаг. Гэрээний хүчинтэй хугацаа 2 жил (Зураг 19, Хавсралт 11).
2	Хамгаалах хувцас хэрэгсэл хангалтгүй байх, хэрэглэж хэвшээгүйгээс шалтгаалж осол аваар гарах	Үйлдвэрийн бүх ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр (тоос шүүх маск, чихний аппарат, хамгаалалтын малгай, бээлий, тусгай зориулалтын хувцас) бүрэн хангаж, хэрэглүүлж хэвшүүлэх	Үйлдвэрийн бүх ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр (тоос шүүх маск, чихний аппарат, хамгаалалтын малгай, бээлий, тусгай зориулалтын хувцас) бүрэн хангаж, хэрэглүүлж хэвшүүлсэн (Зураг 20-21).
3	Ослын нөхцөл хүндрэх	Анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг байнга бэлэн байлгах	Үйлдвэр дээр гарсан гэнэтийн болзошгүй аюул осол эсвэл ажилчдын бие гэнэт муудах зэрэг үед ашиглах анхан шатны тусламжийн эм, тариа, бусад хэрэгслийг үйлдвэрийн оффист тогтмол бэлэн байлгадаг. Ашиглаж дууссан болон хугацаа нь дууссан эм тариаг сэлбэж, шинэчлэдэг (Зураг 22-23).
4	Болзошгүй аюул ослын улмаас гал гарах	Гал унтраах анхан шатны болон суурин тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийн бүрдлийг хангаж, галын хорыг цэнэглэх	Үйлдвэрийн гадна болон дотор орчны хэд хэдэн цэгүүдэд гал унтраах анхан шатны зөөврийн болон суурин тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийн бүрдлийг байрлуулж, галын хорыг цэнэглэн байнгын бэлэн байдалд байлгаж байна (Зураг 24).

1. ХАБЭА болон болзошгүй осол аваарын үед анхан шатны тусламж үзүүлэх сургалтыг “Монголын хүний нөөц удирдлагын шинэчлэлийн академи”-тай 2022 оны 05 сарын 17-ны өдөр байгуулсан гэрээний дагуу тогтсон хуваариар ажлын байранд явуулдаг. Гэрээний хүчинтэй хугацаа 2 жил. Гэрээг хавсралт (11)-аас харна уу.



Зураг 19. Ажилчид ХАБЭА-н сургалтанд хамрагдаж буй байдал

2. Үйлдвэрийн бүх ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж, хэрэглүүлж хэвшүүлсэн. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлд жил бүр 3.600.000 төгрөг зарцуулдаг бөгөөд нүдний шил, маск, бээлий, чихэвч, гутал, хувцас гэсэн иж бүрэн хэрэгслээр бүх ажилчдыг хангадаг.





Зураг 20. Үйлдвэрийн ХАБЭА-н шаардлага хангасан хувцас, хэрэгслийн иж бүрдэл



Зураг 21. Үйлдвэрийн орчинд ажиллаж буй ажилчид аюулгүй ажиллагааны шаардлага хангасан хувцас хэрэгслээр хангагдсан байдал

3. Үйлдвэр дээр гарсан гэнэтийн болзошгүй аюул осол эсвэл ажилчдын бие гэнэт муудах зэрэг үед ашиглах анхан шатны тусламжийн эм, тариа, бусад

хэрэгслийг үйлдвэрийн оффист тогтмол бэлэн байлгадаг. Ашиглаж дууссан болон хугацаа нь дууссан эм тариаг сэлбэж, шинэчлэдэг.



Зураг 22. Үйлдвэрт бэлэн байлгадаг анхан шатны тусламжийн хэрэгслүүд



Зураг 23. Шаардлагатай үед зарим ажилчдад анхан шатны тусламж үзүүлж буй байдал

4. Үйлдвэрийн гадна болон дотор орчны хэд хэдэн цэгүүдэд гал унтраах анхан шатны зөөврийн болон суурин тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийн бүрдлийг байрлуулж, галын хорыг цэнэглэн байнгын бэлэн байдалд байлгаж байна. Галын аюул гарсан тохиолдолд авах арга хэмжээний зааварчилгаа бүхий ханын самбаруудыг мөн байрлуулсан.





Зураг 24. Гал унтраах зөөврийн болон суурин тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг
бэлтгэсэн байдал

ТАВ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт
1	Ахуйн хатуу, шингэн	Хогийн цэгүүд болон тухайн орчны газрыг тогтмол ариутган халдваргүйжүүлэх арга хэмжээ авах	“Хунт Хайрхан” ХХК-тай байгуулсан “Ахуйн шавж мэрэгч устгал, халдваргүйтгэлийн ажлын гэрээ”-ний дагуу үйлдвэрийн талбай дахь хатуу, шингэн хаягдлын цэгүүд болон ажилчдын амрах байр цайны газар, оффист тогтмол ариутгал халдваргүйжүүлэлт хийж байна. Гэрээний хүчинтэй хугацаа: 2024.04.19. Гэрээг хавсаргав (Хавсралт 12).
2	Хатуу хаягдал	Үйлдвэрийн хашааны гадна орчны ахуйн хатуу хаягдлыг цэвэрлэх	Үйлдвэрийн хашааны гадна орчны авто зам дагуух болон хашааны булан тохой хэсэг дэх хуримтлагдсан хатуу хаягдлыг нийт ажилчдын бүрэлдэхүүнээрээ сард нэг удаа цэвэрлэх үйл ажиллагаа явуулдаг (Зураг 25-26).
3	Хатуу хаягдал	Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр, дахивар нөөцийн цэгтэй гэрээ байгуулж ангилан ялгасан дахин боловсруулах боломжтой (Хуванцар, цаас, картон, гялгар уут, шил, лааз, батарей, аккумулятор г.м) хатуу хаягдлыг нийлүүлэх, дахин боловсруулах боломжгүй хаягдлыг хог хаягдлын төвлөрсөн цэг рүү тээвэрлэх	Үйлдвэрийн идэвхитэй үйл ажиллагааны үед нийт 35 хүн ажилладаг ба хоногт 10 кг орчим хатуу хаягдал үүсдэг. Эдгээр хаягдлыг шил, лааз (хуванцар), цаас, дахин боловсруулах боломжгүй хаягдал гэсэн 4 төрөлд ангилан ялгаж хуримтлуулдаг. Хуванцар, шил, лааз болон цаасыг дахивар нөөцийн цэгүүдэд өөрсдийн тээврийн хэрэгслээр тээвэрлэн хүргэж өгдөг. Харин дахин боловсруулах боломжгүй хаягдлыг СХД-н Тээвэрлэлт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай байгуулсан “Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээ”-ний дагуу төвлөрсөн хаягдлын цэг рүү сард 2-3 удаа ачуулан үйлдвэрийн талбайгаас зайлуулж байна. Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээний хүчинтэй хугацаа: 2023.12.31 хүртэл (Зураг 27 , Хавсралт 13).
4	Шингэн хаягдал	Бохирын цооногийн дүүрэлтийг 80 хувиас хэтрүүлэхгүй соруулан зайлуулах	“Ар Халхын нүүдэл” ХХК-тай байгуулсан бохир ус тээвэрлэх гэрээний дагуу соруулан зайлуулдаг. Гэрээг 2023.05.09-ний өдөр байгуулсан ба 1 жилийн хугацаанд хүчинтэй (Зураг 28 , Хавсралт 14).

1. “Хунт хайрхан” ХХК-тай байгуулсан “Ахуйн шавж мэрэгч устгал, халдваргүйтгэлийн ажлын гэрээ”-ний дагуу үйлдвэрийн талбай дахь хатуу, шингэн хаягдлын цэгүүд болон ажилчдын амрах байр цайны газар, оффист тогтмол ариутгал халдваргүйжүүлэлт хийж байна. Гэрээний хүчинтэй хугацаа: 2024.04.19 хүртэл үргэлжилнэ. Ахуйн шавж мэрэгч устгал, халдваргүйтгэлийн ажлын гэрээг хавсралтаас үзнэ үү.

2. Үйлдвэрийн хашааны гадна орчны авто зам дагуух болон хашааны булан тохой хэсэг дэх хуримтлагдсан хатуу хаягдлыг нийт ажилчдын бүрэлдэхүүнээрээ сард нэг удаа цэвэрлэх үйл ажиллагаа явуулдаг.



Зураг 25. Үйлдвэрийн хашааны гадны орчныг нийт ажилчдын бүрэлдэхүүнээрээ цэвэрлэж буй байдал



Зураг 26. Үйлдвэрийн хашаа руу орох хэсгийн харагдах байдал

3. Үйлдвэрийн идэвхитэй үйл ажиллагааны үед нийт 35 хүн ажилладаг ба хоногт 10 кг орчим хатуу хаягдал үүсдэг. Эдгээр хаягдлыг шил, лааз (хуванцар), цаас, дахин боловсруулах боломжгүй хаягдал гэсэн 4 төрөлд ангилан ялгаж хуримтлуулдаг. Хуванцар, шил, лааз болон цаасыг дахивар нөөцийн цэгүүдэд өөрсдийн тээврийн хэрэгслээр тээвэрлэн хүргэж өгдөг. Харин дахин боловсруулах боломжгүй хаягдлыг СХД-н Тээвэрлэлт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай байгуулсан “Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээ”-ний дагуу төвлөрсөн хаягдлын цэг рүү сард 2-3 удаа ачуулан үйлдвэрийн талбайгаас зайлуулж байна. Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээний хүчинтэй хугацаа: 2023.12.31 хүртэл. Гэрээг хавсаргав.



Зураг 27. Ахуйн хатуу хаягдлыг ангилан ялгаж хуримтлуулах цэг

4. Ахуйн шингэн хаягдлын хувьд ус хэрэглээнээс хамаараад хоногт 2м³ орчим хаягдал үүсэх ба шингэн хаягдлыг 60.0 м³-ийн багтаамжтай доторлогоотой бохирын цоонгогт хуримтлуулж “Ар Халхын нүүдэл” ХХК-тай байгуулсан бохир ус тээвэрлэх гэрээний дагуу соруулан зайлуулдаг. Мөн ажилчдын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэн байгуулж бохирын цоонгогтой холбосон болно. Гэрээг 2023.05.09-ний өдөр байгуулсан ба 1 жилийн хугацаанд хүчинтэй.

2023 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Туул голын сав газрын захиргаагаар Хаягдал усны дүгнэлт гаргуулсан. Хаягдал усны дүгнэлтээр жилд 381 м³ хаягдал ус гарах тооцоо гаргасан бөгөөд 28560 төгрөгийн төлбөр ногдуулсан байна. Төлбөрийг төлж барагдуулсан болно. Хаягдал усны дүгнэлт болон бохир соруулах үйлчилгээ үзүүлэх гэрээг хавсралтаас үзнэ үү.



Зураг 28. Бохирын цооногийн гаднаас харагдах байдал

ЗУРГАА. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

6.1. Агаарын чанарын мониторинг

Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газартай байгуулсан гэрээний дагуу үйлдвэрийн талбайн орчны болон уурын зуухны яндангаас ялгарч буй агаар бохирдуулагчийн хэмжилтийг хийлээ. Агаарын чанарын хэмжилтийн үр дүнгээс үзэхэд үйлдвэрийн талбайн орчны агаар дахь $PM_{2.5}$ тоосны агууламж 38 мкг/м^3 , PM_{10} тоосны агууламж 82, SO_2 -ын агууламж 122 мкг/м^3 , CO -ийн агууламж 204 мкг/м^3 байгаа нь агаарын чанарын стандарт (MNS 4585:2016) – ын ЗДХ-ээс бага үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3. Үйлдвэрийн талбайн орчны агаарын чанарын хэмжилтийн үр дүн

Хэмжилт хийсэн цэг, байршил	Агаарын чанарын хэмжилт хийсэн үзүүлэлт			
	$PM_{2.5}$, мкг/м^3	PM_{10} , мкг/м^3	SO_2 , мкг/м^3	CO , мкг/м^3
Үйлдвэрийн талбай	38	82	122	204
MNS4585:2016 стандартын ЗДХ	50	100	450	60000

Мөн уурын зуухны яндангаас ялгарч буй бохирдуулагч бодисын агууламжийг эх үүсвэр дээр нь тодорхойлоход “Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны агаар мандалд хаях утааны бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, хэмжих арга, MNS 5919:2008 стандарт”-д заасан ЗДХ-ээс бага гарсан болно.

Хүснэгт 4. Уурын зуухны яндангаас ялгарах бохирдуулагч бодисуудын хэмжилтийн үр дүн

Үзүүлэлт	NO_x , мг/м^3	SO_2 , мг/м^3	CO , мг/м^3	TSP, мг/м^3
Агууламж	211	581	551	3193
MNS 5919:2008	1150	1620	1030	12000

Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар нь өөрсдийн хэмжилтийн багаж, техник хэрэгслийн хамтаар ирж бохирдуулагч бодисуудын хэмжилтийг үйлдвэрийн идэвхитэй үйл ажиллагааны үед хийж гүйцэтгэсэн (Зураг 29-30).



Зураг 29. Уурын зуухны яндангаас ялгарах бохирдуулагчийн хэмжилт хийж буй байдал



Зураг 30. Үйлдвэрийн гадна орчны агаарын чанарын хэмжилт хийж буй байдал

Агаарын чанарын хэмжилтийн үр дүнг тайлангийн хавсралтаас харна уу (Хавсралт 15).

6.2. Усны чанарын мониторинг

Усны чанарын мониторингийн ажлын хүрээнд үйлдвэрийн талбай дахь гүний худгаас дээж авч “Геологийн судалгаа шинжилгээний төв” ТӨҮГ-ын химийн шинжилгээний лабораторид шинжлүүлсэн бөгөөд усны найрлага дахь химийн 30 элементийг тодорхойлж стандартын ЗДХ-тэй харьцуулав. Усны шинжилгээг 2023 оны 05 дугаар сарын 29-ны өдөр хийсэн. Усны химийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд хоёр гүний худгийн ус нь газрын доорх усны чанарын шаардлагыг хангаж байна. Шинжилгээний үр дүнг хавсаргав (Хавсралт 16).

Хүснэгт 5. Усны химийн шинжилгээний үр дүн

Үзүүлэлт	Үр дүн	СУУ	ШУ	Үзүүлэлт	Үр дүн	СУУ	ШУ
	Мг/л				Мг/л		
Мөнгө (Ag)	<0.1	0.30	0.30	Хар тугалга (Pb)	<0.1	0.30	0.31
Хөнгөн цагаан (Al)	<0.1	0.30	0.31	Сканди (Sc)	<0.1	0.30	0.31
Мышьяк (As)	<0.1	0.30	0.27	Цахиур (Si)	6.06	3.0	2.99
Бор (B)	<0.5	0.30	2.95	Цагаан тугалга (Sn)	<0.1	0.30	0.34
Бари (Ba)	<0.1	0.30	0.29	Стронци (Sr)	0.74	0.30	0.30
Берилли (Be)	<0.1	0.30	0.29	Титан (Ti)	<0.1	0.30	0.30
Кадми (Cd)	<0.1	0.30	0.30	Ванади (V)	<0.1	0.30	0.29
Кобальт (Co)	<0.1	0.30	0.30	Иттри (Y)	<0.1	0.30	0.30
Хром (Cr)	<0.1	0.30	0.29	Цайр (Zn)	<0.1	0.30	0.30
Зэс (Cu)	<0.1	0.30	0.28	Сурьма (Sb)	<0.1	0.30	0.29
Төмөр (Fe)	<0.03	0.30	0.29	Селени (Se)	<0.1	0.30	0.29
Лантан (La)	<0.1	0.30	0.30	Кальци (Ca)	63.85	35.0	35.08
Манган (Mn)	<0.1	0.30	0.29	Кали (K)	1.39	2.50	2.49
Молибден (Mo)	<0.1	0.30	0.29	Магни (Mg)	12.39	9.00	8.89
Никель (Ni)	<0.1	0.30	0.29	Натри (Na)	18.49	6.00	5.94

**Тайлбар: СУУ – Стандарт уусмалын утга
ШУ – Шинжилсэн утга

6.3. Хөрсний чанарын мониторинг

Хөрсний чанарын мониторингийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр үйлдвэрийн хашаан доторх 4 цэгт 0-25 см гүнтэй өнгөн зүсэлт хийж, нийт 4 ширхэг дээж аван агрохими болон хүнд металлын агууламжийг тодорхойлсон. Шинжилгээг “Инженер геодези” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид хийлгэсэн.



Зураг 31. Хөрсний дээж авч буй байдал

Шинжилгээний үр дүнгээс үзэхэд хөрсний үржил шимийг илтгэгч ялзмагийн агууламж нь 0-25 см-ийн гүнд 1.8-2.29% байгаа нь дунд зэрэг, урвалын орчин нь 7.54-8.24 буюу сулаас дунд зэргийн шүлтлэг, карбонатын агууламжгүй, сул давсархаг, ургамлын өсөл хөгжилтөнд хамгийн чухал нөлөө үзүүлдэг шим тэжээлийн макро элементүүд болох хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар сайн байна (Хүснэгт 6). Харин хөрсний механик бүрэлдэхүүний хувьд үйлдвэрийн хашааны баруун, баруун урд, зүүн урд хэсэгт 0-25 см-ийн гүндээ элсэнцэр, урд хэсгээрээ хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна (Хүснэгт 7).

Хүснэгт 6. Хөрсний агро-хими шинж чанар

Дээжийн нэр	Дээж авсан гүн, см	pH	Давс	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	CaCO ₃ , %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
							Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
Баруун урд	0-25	7.82	0.15	0.329	1.80	0.0	12.6	6.0	-	64
Баруун	0-25	8.24	0.08	0.182	2.11	0.0	17.6	6.3	-	54
Урд	0-25	8.23	0.09	0.201	2.29	0.0	18.6	5.8	-	45
Зүүн урд	0-25	7.54	0.16	0.355	1.96	0.0	13.4	4.6	-	42

Хүснэгт 7. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжийн нэр	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд (%), ширхэгийн хэмжээ (мм)							Механик бүрэлдэхүүний нэр
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
Баруун урд	0-25	2.6	53.1	26.5	11.0	2.1	4.8	17.8	Элсэнцэр
Баруун	0-25	3.7	41.3	34.9	11.6	4.0	2.5	18.1	Элсэнцэр
Урд	0-25	2.5	37.1	37.9	12.6	5.8	4.1	22.5	Хөнгөн шавранцар
Зүүн урд	0-25	4.8	42.0	32.4	4.7	5.6	9.5	19.8	Элсэнцэр

Түүнчлэн дээрх 4 цэгээс хүнд металлын дээж авч лабораторийн шинжилгээ хийлгэсэн. Хөрсний хүнд металл гэдэг нь нягт нь 5 г/см^3 –ээс илүү, атом масс нь 40-өөс илүү, хөрсөнд тогтвортой удаан хугацаагаар хадгалагддаг, амьд организмд аюултай хор нөлөө үзүүлдэг, уусах чанар багатай, удаан задардаг био-идэвхт, хортой, онцгой хортой элементүүд юм.

Шинжилгээгээр Зэс (Cu), Хром (Cr), Никель (Ni), Хар тугалга (Pb), Цайр (Zn), кадми (Cd) гэсэн 6 элементүүдийг тодорхойлж, MNS 5850:2019 стандартын зөвшөөрөгдөх дээд агууламжтай харьцуулахад хүлцэх агууламжаас даруй хэд дахин бага буюу хүнд металлын бохирдол илрээгүй болно (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Хөрсний хүнд металлын агууламж

№	Дээжийн нэр	Дээж авсан гүн, см	Хүнд металл мг/кг					
			Ni	Cd	Pb	Cu	Zn	Cr
1	Баруун урд	0-25	32.5	ND	7.01	3.82	75.5	11.6
2	Баруун	0-25	48.8	ND	18.3	20.4	87.1	10.5
3	Урд	0-25	44.5	ND	19.8	18.5	63.9	9.54
4	Зүүн урд	0-25	43.9	ND	19.6	18.6	49.7	ND
Хүлцэх агууламж / MNS 5850:2019/			150.0	3.0	100.0	100.0	300.0	150.0
Хортой агууламж /MNS:5850:2019/			1000.0	10.0	500.0	500.0	600.0	400.0
Аюултай агууламж /MNS 5850:2019/			1800.0	20.0	1200.0	1000.0	1000.0	1500.0

**ДОЛОО. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	2023 оны БОМТ – г хэрэгжүүлэхэд зарцуулсан төсөв, мян.төг	Хариуцсан албан тушаалтан
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1150.0	Компаний захирал, үйлдвэрийн дарга, байгаль орчны ажилтан
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1000.0	Байгаль орчны ажилтан
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500.0	ХАБЭА-н ажилтан
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2590.0	Байгаль орчны ажилтан
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	730	Байгаль орчны ажилтан
Нийт		5970.0	-

ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1: Техникийн үзлэг оношилгооны баримт

10/17/22, 4:41 PM

about:blank

Илгээгдсэн

Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт



ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 00000532416500220905090513214853
Борлууллагчийн: ТТД: 6324165
НЭР: АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
Хаяг: Монгол, Улаанбаатар, Сүхбаатар, 2-р хороо, Тээвэрчдийн гудамж, Засгийн газрын XIII-р байрны өргөтгөл
Утас: 70127042, 70127042, 70127042, 70127042, 70127042, 70127042, 70127042, 88085224, 8808056, 99858385
Банкны нэр: Банкны дансны дугаар:

Огноо: 2023.09.05
Худалдан авагчийн: ТТД: 6717906
